

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын 2022 оны 04 сарын 21-ний өдрийн 1/10 тоот удирдамж аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Орхон сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, боловсролын холбогдох хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр 2022 оны 04 дүгээр сарын 25-аас хуанлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Цэцэрлэгийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Тус цэцэрлэг нь 2020-2021 оны хичээлийн жилд эрхлэгч 1, багш 3, туслах багш 3, тогооч 1, нярав 1, үйлчлэгч 1, слесерь 1 нийт 11 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. Тус цэцэрлэгийн 1-р гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-ээс 2021 оны 12 сарын 31-нийг дуустал хугацаанд эрхлэгч Л.Ариунзаяа, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 1 сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нягтлан бодогч Д.Өлзийхутаг нар зурж, төрийн санд бүртгэлийн 100040715201 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох "CTS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

Эд хариуцагчаар С.Эрдэнэцэцэг ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус цэцэрлэг нь 2021 онд Төрийн аудитын байгууллагын түүвэрт хамрагдсан байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад тус сургууль 2021 онд төсөв гүйцэтгэл цэсэнд 51 мэдээлэл мэдээллэхээс 5 мэдээллийг, хөрөнгө оруулалт тендэр худалдан авалт цэсэнд 39 мэдээлэл мэдээллэхээс 5 мэдээллийг, бусад цэсэнд 61 мэдээлэл мэдээллэхээс 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн байна.

ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус байгууллагын 2021 оны касс, харилцах, аж ахуйн баримт, өмч хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, хүнсний агуулахын бүртгэл, багшийн журнал, дотуур байрны багшийн бүртгэл, санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Л.Ариунзаяа, нягтлан бодогч Д.Өлзийхутаг, нярав С.Эрдэнэцэцэг нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

8.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2021 онд улсын төсвөөс 223,338.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 223,338.3 төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 191,074.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 18,079.4 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 1,250.3 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 28,279.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 29,9 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 459,8 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 292,4 мянган төгрөг, шуудан, холбооны зардалд 300.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 3,490.9 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 4,259,2 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 317,0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 595,0 мянган төгрөг, дотоод

албан томилолтын зардалд 56,0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 171,5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 247,2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 775,4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 21,159.6 мянган төгрөг, нийт 212,291.2 мянган төгрөг зарцуулж 57,0 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар: Тус цэцэрлэгийн эрхлэгчид Сумын Засаг даргын 2021 оны Б/06 тоот захирамжаар 2021 оны 7 сарын 1-ээс 10 сарын 1-ний өдрийг хүртэл 25%-аар ур чадварын нэмэгдэл 526,3 мянган төгрөг, 2021 оны 09 сарын 22-ны өдрийн Б/11 тоот захирамжаар 3-р улирлын урамшуулалд 45 хувиар 434,2 мянган төгрөг, Б/17 тоот захирамжаар 10 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл 20%-иар тооцон ур чадварын нэмэгдэл 192,9 мянган төгрөг, Б/18 тоот захирамжаар 4 дүгээр улирлын урамшуулал 45 %-аар 434,2 мянган төгрөг нийт 1,587.6 мянган төгрөг олгосон байна.

Эрхлэгчийн 2021 оны 4 сарын 20-ны өдрийн А/03 тоот тушаалаар 1 дүгээр улирлын урамшуулалд 11 багш, ажиллагсадад 30-60%-аар тооцон 2,526.5 мянган төгрөг, А/09 тоот тушаалаар 2 дугаар улирлын урамшуулал 10 багш ажиллагсадад 35-60%-аар тооцон 3,101.6 мянган төгрөг, А/13 тоот тушаалаар 3 дугаар улирлын урамшуулал 11 багш ажиллагсадад 20-55%-аар 3,518.5 мянган төгрөг, А/16 тоот тушаалаар 4 дүгээр улирлын урамшуулал 11 багш ажиллагсадад 30-59 %-аар тооцон 3,993.7 мянган төгрөг, А/14 тоот тушаалаар 10 багш ажиллагсадад 15%-аар тооцон ур чадварын нэмэгдэл 962,0 мянган төгрөг, нийт 14,102.3 мянган төгрөг олгожээ.

8.2 Өглөг, авлагын талаар: 2021 оны жилийн эцэст өглөг, авлагагүй байна.

8.3.Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

2021 оны эхэнд барилга байгууламж 306,959.7 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 33,438.1 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 7,437.6 мянган төгрөг, номын фонд 4,245.9 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 29395.1 мянган төгрөг, програм хангамж 550.0 мянган төгрөг, бусад биет хөрөнгө 18,140.0 мянган төгрөг, программ хангамж 1,900.0 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 14,646.0 мянган төгрөг нийт 387,767.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсанаас машин тоног төхөөрөмжид төсвийн хөрөнгөөр 3,499.0 мянган төгрөг, тавилга эд хогшилд 8,490.0 мянган төгрөг, номын фонд 57,0 мянган төгрөг нийт 12,046.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогодож эрхлэгчийн 2021 оны 05 сарын 25-ны өдрийн А/07 тоот тушаалаар 2021 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор цаашид ашиглах ашиглалтын хугацаа дууссан 4 нэр төрлийн 6,468.0 төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг тоног төхөөрөмж, 5 нэр төрлийн 1,073.0 мянган төгрөгийн өртөг бүхий 60 ширхэг тавилга эд хогшил, 4 нэр төрлийн 6,389.1 мянган төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг бусад үндсэн хөрөнгө, нийт 3 нэр

төрлийн 74 ширхэг 13,935.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж оны эцэст 385,878.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

2021 оны эхний үлдэгдэл бичиг хэргийн материал 223,6 мянган төгрөг, аж ахуйн материал 451,0 мянган төгрөг, барилгын засварын материал 390,0 мянган төгрөг, хүнсний материал 1,695.8 мянган төгрөг, бусад хангамжийн материал 19,574.5 мянган төгрөг нийт 22,334.9 мянган байсанаас төсвийн хөрөнгөөр 16,759.8 мянган төгрөгийн материал худалдан авч 10,455.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 28,639.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

ЕС. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Тус цэцэрлэгийн 3 багшид ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан 104539 төгрөгийг илүү олгосон.

2. Авсан шатахууны мөнгөн дүнд тааруулж жолоочийн тооцооны хуудас бичдэг, жолоочтой шатахууны зарцуулалтын тооцоог нийлж, акт үйлдээгүй, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулсан боловч эд хариуцагчийн тооллого тооцоог бодож акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй.

3. О.Пүрэвдуламыг 04 сарын 01-ний өдрөөс үндсэн багшаас чөлөөлөн, туслах багшаар ажилуулсан боловч тушаал шийдвэрийг баримт материалд хавсаргаагүй.

4. Няравын тайланг хянаж шалгаж хүлээж авдаггүй, тооцоо боддоггүй.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 1 актаар 104539 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлүүд дахин давтан гарч байна гэж дүгнэлээ.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулах

Илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй таслан зогсоох талаар тодорхой ажил зохион байгуулах

Актаар тогтоосон төлбөрийг хугацаанд нь барагдуулж хариуг албан бичгээр ирүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ А.АНХБАЯР

Илүү олгосон амралтын олговрыг төлүүлэх тухай

Булган аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 01/10 тоот удирдамжийн дагуу Булган аймгийн Орхон сумын Өсөх-Ирээдүй цэцэрлэгийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын санхүү, төсөвийн тухай хууль, боловсролын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилт, хандив тусламжаар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан шийдвэр, санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт зэрэг баримт материалуудад тулгуурлан, Санхүүгийн хяналт аудитын албаны хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр 2021 оны 04 сарын 25-наас 5 хоногийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Шалгалтаар: Тус цэцэрлэгийн 3 багшид ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д /Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна./, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралт Ээлжийн амралт олгох зааварын 2-т / Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх болоцоогоор хангаж, эдлүүлнэ./, 13-т /Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй/ заасан заалтуудыг зөрчсөн байна. /Хавсралт-1/

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 10.12.2 дох /Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын

орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх/ заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон 104539 төгрөгийг эрхлэгч Л.Ариунзаяа, нягтлан бодогч Д.Өлзийхутаг нараар хувь тэнцүүлэн төлүүлж төсвийн орлого болгосугай.

2.Төлбөрийн 104539 төгрөгийг Булган аймгийн Төрийн сангийн хүү торгуулийн 100040000988 тоот дансанд 2022 оны 06 дугаар сарын 25-ны дотор актын дагуу барагдуулахыг санхүү албаны дарга Т.Бурмаад актаар хариуцуулсугай.

3.Улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гомдлоо гаргаж болохыг дурьдсугай.

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
Б.БАТТУЛГА
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ
А.АНХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:
САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА
Т.БУРМАА
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.АРИУНЗАЯА
НЯГТЛАН БОДОГЧ
Д.ӨЛЗИЙХУТАГ

